

**АРХАНГАЙ АЙМГИЙН САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, ДОТООД АУДИТЫН ГАЗРЫН
АЛБАН ХААГЧДЫН АЖИЛЛАХ НӨХЦӨЛ, НИЙГМИЙН БАТАЛГААГ
ХАНГАХ ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТ**

2025 оны 12 дугаар сарын 05

Эрдэнэбулган сум

Аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын газрын ажилтан албан хаагчдын нийгмийн баталгааг хангах хөтөлбөрт түүнийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны 5 чиглэлээр 22 ажил арга хэмжээг 2015-2025 он дуустал 2 үе шаттайгаар авч хэрэгжүүлэхээр хамт олны хурлаар хэлэлцэн баталж, жил жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлж байна. Хөтөлбөрт тусгагдсан нийт 8 арга хэмжээг 2025 онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн. Энэ хүрээнд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлж, нийт 74.6 сая төгрөгийн төсөв зарцуулсан. Үүнд:

- Ажлын байрны нөхцөл сайжруулах зорилтын хүрээнд тавилга эд хогшил, компьютер тоног төхөөрөмжийг шинэчлэх, автомашины засвар үйлчилгээнд нийт 11.5 сая төгрөг зарцуулж, ажиллах нөхцлийг сайжруулан ая тохитой орчныг бүрдүүлсэн.

- Ажилтан албан хаагчдад хагас жил тутам ажлын үр дүнгээр 20.8 сая төгрөгийн мөнгөн урамшуулал олгосон.

- Ажилтны эрүүл мэндийг дэмжих, эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор аймгийн Биеийн тамир спортын газарт хүсэлт тавьж, ажилтан албан хаагчдыг Сорилын төвд биеийн ерөнхий түвшин тогтоох үзлэгт бүрэн хамруулж, зөвлөгөө авсан нь тэдний сэтгэлд хүрсэн ажлын нэг боллоо. Мөн Монгол улсын Ерөнхийлөгчийн санаачилгаар хэрэгжүүлж буй “Эрүүл монгол хүн” үндэсний хөдөлгөөнийг аймгийн хэмжээнд зохион байгуулах арга хэмжээний нэгдсэн удирдамжийн хүрээнд хуваарийн дагуу 5 дугаар сард 7 хоног бүрийн Лхагва, Баасан гарагт өглөөний алхалтад нийт ажилтан албан хаагчид оролцлоо.

- Ажлын байрны эрүүл ахуйн нөхцөлийг сайжруулах, ажилтнуудын дунд спортын уралдаан тэмцээн зохион байгуулах, спорт зааланд тоглуулах, албан хаагчдын чөлөөт цагийг зөв өнгөрүүлэх зорилтын хүрээнд гэрээний үндсэн дээр 7 хоногт 2 цаг зал авч аймгийн Соёл урлаг, аялал жуулчлал, залуучуудын газартай хамтран ажилладаг. Энэ оны 5 дугаар сард аймгийн Засаг даргын Тамгын газар, Санхүү, төрийн сангийн хэлтэстэй хамтран зохион байгуулсан Санхүү бүртгэлийн ажилтны шилжин явах цомын төлөөх 3 төрөлт тэмцээнд амжилттай оролцож, “Анхдугаар цомын эзэн баг”-аар шалгарч Шилжин явах цом, Өргөмжлөлөө гардан авсан.

- Хөтөлбөрт тусгагдсан арга хэмжээ буюу хоолны үнийн хөнгөлөлтийг сар бүр тооцож, ажилтан албан хаагчдад нийт 25.2 сая төгрөг олгосон байна.

- Ажилтан албан хаагчдын гэр бүлд хүндэтгэл үзүүлж, ажилтны хүүхдүүдэд эх үрсийн баяраар бэлэг гардуулсан. Мөн дотоод журмын хүрээнд албан хаагчдад хүндэтгэл үзүүлэх, архив-бичиг хэргийн ажилтанд дэмжлэг үзүүлэхэд нийтдээ 8.0 сая төгрөг зарцуулсан. Ажилтны хувийн шалтгаантай тохиолдолд Хөдөлмөрийн дотоод журамд заасны дагуу албан хаагчид давхардсан тоогоор 16 удаа цалинтай чөлөөг олгож шийдвэрлэсэн.

- Сургалтын төлөвлөгөөний хүрээнд албан хаагчид танхим болон цахимаар 34 сургалтад бүрэн хамрагдсан дүнтэй гарлаа. Архив-бичиг хэргийн ажилтныг

мэргэшүүлэх сургалт, Мэргэшсэн нягтлан бодогч эрхтэй аудитор, улсын байцаагчдыг мэргэжлийн тасралтгүй хөгжил, газрын дарга, ахлах дотоод аудитор, дотоод аудиторуудыг МҮДАХ, Сангийн яам, Азийн хөгжлийн банк, Баянгол дүүргийн Дотоод аудитын албанаас зохион байгуулсан уулзалт зөвлөгөөн, үзүүлэх сургалтад хамруулж, сургалтын зардал, аймгийн Төсөв захирагч, санхүү бүртгэлийн ажилтны нэгдсэн сургалт, зөвлөгөөний зардалд нийтдээ 9.1 сая төгрөг тус тус зарцуулсан.

Хөтөлбөрийн хэрэгжилт 100%-тай байна.

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ



Д.ГАНДОЛГОР

Санхүүгийн хяналт, дотоод аудитын газар

Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах
хөтөлбөрийн биелэлтийг тайлагнах хүснэгт

2025 оны 12 сарын 05

№	Үйл ажиллагаа	№	Шалгуур үзүүлэлт	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин	Тайлбар
Хүний нөөцийг хөгжүүлэх, идэвхжүүлэх						
1	Засгийн газар, төрийн байгууллага, бусад байгууллагаас албан хаагчдын мэдлэг, мэргэжлийг дээшлүүлэх чиглэлээр зохион байгуулсан дотоод сургалт	1.1	Нийт сургалт семинар, зөвлөгөөний тоо	14	34	Сангийн яам, Авлигатай тэмцэх газар, Татварын газар, Цахим үйлчилгээний хэлтэс, Хот байгуулалт барилга орон сууцжуулалтын яам, Аминь орон сууцны мэдээлэл дамжуулах төв, Засаг даргын тамгын газар, Худалдан авах ажиллагааны газар, Хүүхэд гэр бүл хөгжил хамгааллын газар, Төрийн албаны зөвлөл, Стандарт хэмжил зүйн хэлтэс зэрэг газруудаас зохион байгуулсан сургалтад бүх албан хаагчид хамрагдсан байна.
		Үүнээс	Ажлын байран дахь сургалт	6	11	- Дотоод аудитын удирдлагын мэдээллийн нэгдсэн системийн сургалт - Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн хөтөлөлтөд хамрагдахад бүрдүүлэх материал, хувь хүний орлогын албан татварын тайланг цахимаар илгээх тухай -ХАСХОМ шинэчлэн гаргах, Төрийн албан хаагчийн ёс зүй, харилцаа хандлага -Хувь хүний харилцаа хандлага, Үг үйлдлээ анхаарахуй -Өргөдөл гомдолын системийн танилцуулга -Цахим суурьтай бичиг баримт боловсруулах, ДОСК системийг нэвтрүүлэх -Бодлогын баримт бичгийг үр дүнд суурилсан арга зүйгээр боловсруулах -Илтгэх үр чадвар, Үг үйлдэлээ анхаарахуй зэрэг сургалтад хамрагдсан байна.
			Мэргэшүүлэх сургалт	2	4	- Архивын ерөнхий газраас зохион байгуулсан "Төрийн архивын ажлын зохион байгуулалт, архивын баримт цахимжуулалт, баримт бичгийн стандарт, баримт бичиг зохион бүрдүүлэх арга зүй"

					- ММНБИ-ээс зохион байгуулсан Төвийн бүсийн аймгуудын мэргэжлийн тасралтгүй хөгжлийн сургалт - Хуададан авах ажиллагааны газраас зохион байгуулсан "Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авах тухай" - Монголын Үндэсний дотоод аудиторуудын холбооноос зохион байгуулсан "Хиймэл оюун ухааныг дотоод аудитад ашиглах нь" сэдэвт сургалтад албан хаагчид хамрагдсан. Сангийн яам, Хөвсгөл аймаг, Баянгол дүүргийн дотоод аудитын албанаас зохион байгуулсан үзүүлэх сургалтад дарга, 4 дотоод аудитор хамрагдсан.
	Туришлага солилцох арга хэмжээ	1	2		-Авилгагүй Архангай аян -Ногоон, Эрсдэлд тэсвэртэй, орлогод нийцсэн орон сууц -Хүний эрхийг хамгаалах механизм -Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авах тухай -Хүүхэд хамгааллын тухай хууль -Албан тушаалын тодорхойлолтыг цахим системд бүртгэх нь -Стандартай Архангай бага хурал зэрэг суралтад албан хаагчид хамрагдсан байна.
	Бусад	3	17		
	Хамрагдсан нийт албан хаагчдын тоо	84	138		
1.2	Эмэгтэй албан хаагч		106		
	Эрэгтэй албан хаагч		32		8 албан хаагч давхардсан тоогоор нийт 138 удаагийн сургалтад албан хаагчид хамрагдаж, мэдлэг, чадвараа дээшлүүлээ.
Үүнээс	Удирдах албан тушаалтан		1		
	Гүйцэтгэх, туслах албан тушаалтан		7		
1.3	Албан хаагчдын сургалтад хамруулсан байдал: Нийт албан хаагчдад эзлэх хувь	90-ээс дээш	100		Сургалтад албан хаагчид 4-18 удаагийн давтамжтай хамрагдсан байна.
	Нийт гадаад сургалт, семинар, зөвлөгөөний тоо				Байхгүй
2.1	Хамрагдсан нийт албан хаагчдын тоо:	-			Байхгүй
2.2	Хамрагдсан нийт албан хаагчдын тоо:	-			Байхгүй
Үүнээс	Эмэгтэй албан хаагч	-			Байхгүй

талын зардлаар хамруулсан гадаад сургалт		Эрэгтэй албан хаагч	-		Байхгүй
		Удирдах албан тушаалтан	-		Байхгүй
		Гүйцэтгэх, туслах албан тушаалтан	-		Байхгүй
		Гадаад сургалтад хамруулсан байдал		-	Байхгүй
	2.3	Нийт албан хаагчдад эзлэх хувь	-	-	Байхгүй
		Албан хаагчдын сургалт, хөгжлийн үйл ажиллагаанд зарцуулсан зардлын хэмжээ (сая.төг)	0.5 сая төгрөг	2.5 сая төгрөг	Мэргэшсэн нягтлан бодогчийн тасралтгүй боловсролын сургалтад 2 албан хаагчийг хамруулсан, архивын сургалтанд 1 албан хаагч, дотоод аудиторын зөвлөгөөнд 3 албан хаагч тус тус хамрагдаж, бүх албан хаагчдад дотоод сургалт зохион байгуулсан.
3	3.1	Албан хаагчдыг хөгжүүлэх, мэргэшүүлэх, чиглэлээр зарцуулсан зардал, албан хаагчдын шилжилт хөдөлгөөн	Албан хаагчдын шилжилт хөдөлгөөний хувь	15-аас доош	Дотоод аудиторын сул орон тоог нөхөх тусгай шалгалтын захиалгыг Төрийн албаны зөвлөлийн Архангай аймаг дахь салбар зөвлөлд 2025 оны 02 сарын 27-ны өдрийн 32 тоот албан бичгээр хүргүүлсэн. Төрийн албаны тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.2, 27.1.3 дахь заалт, "Төрийн албаны тусгай шалгалт өгөх болзол, журам"-ын 2.1, 2.3-т заасныг тус тус үндэслэн гүйцэтгэх албан тушаалын сул орон тоог нөхсөн.
	3.2	Албан хаагчдын шилжилт хөдөлгөөний хувь	15-аас доош	14.3 хувь	

Хэсгийн дундаж: 100%

Албан хаагчдын нийгмийн баталгааг хангах

4	Цалин хөлс, шагнал, урамшууллын тогтолцоог хэрэгжүүлэх	4.1	Цалин шагнал, урамшуулалд зарцуулсан зардлын байгууллагын нийт төсөвт эзлэх хувь	60-с дээш хувь	68.7 хувь	Албаны 8 албан хаагчдын цалин, НДШ-ийн зардалд 337.7 сая төгрөг, 20.8 сая төгрөгийн үр дүнгийн урамшуулал олгосон. Нийт зардлын 63.4 хувийг эзэлж байна.
		4.2	Нэгж албан хаагчдад сар бүр олгох хоол, унааны нэмэгдэл	13.5 сая төгрөг	Албан хаагчдад өдрийн 15.0 мянган төгрөгийн хоол, унааны зардлыг олгосон.	Нийгмийн баталгааг хангах хөтөлбөрт тусгагдсан арга хэмжээ буюу хоолны үнийн хөнгөлөлтийг сар бүр тооцож, ажилтан албан хаагчдад нийт 25.2 сая төгрөг олгосон.

5	Албан хаагчдын ажлын байрны хэвийн нөхцөлийг бүрдүүлсэн байдал	5.1	Ажлын байрны таатай орчны сэтгэл ханамжийн санал асуулга	Сэтгэл ханамж 80 хувиас дээш	100%	2023-2024 онуудад ажлын өрөөнүүдэд засвар үйлчилгээ, тохижилт хийж, ажиллах нөхцөл таатай орчныг бүрдүүлсэн. Албаны автомашинд засвар үйлчилгээ хийсэн. 2025 онд 10.7 сая төгрөгийн тавилга, тоног төхөөрөмж бэлтгэсэн.
6	Албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалах, урьдчилан сэргийлэх	6.1	Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзэлг	Жилд 1-ээс доошгүй удаа	1 удаа	Ажилтны эрүүл мэндийг дэмжих, эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор аймгийн Биеийн тамир спортын газарт хүсэлт тавьж, ажилтан албан хаагчдыг Сорилын төвд биеийн ерөнхий түвшин тогтоох үзэлт бүрэн хамруулж, зөвлөгөө авсан нь тэдний сэтгэлд хүрсэн ажлын нэг боллоо. Мөн Монгол улсын Ерөнхийлөгчийн санаачилгаар хэрэгжүүлж буй "Эрүүл монгол хүн" үндэсний хөдөлгөөнийг аймгийн хэмжээнд зохион байгуулах арга хэмжээний нэгдсэн удирдамжийн хүрээнд хуваарийн дагуу 5 дугаар сарын 7 хоног бүрийн лхагва, Баасан гаратт өглөөний /6.30-07.30/ алхалтад нийт ажилтан албан хаагчид оролцлоо. 2025 оны 11 сард бүх албан хаагчдыг Улаанбаатар хотруу эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзэлт хамруулсан.
		6.2	Албан хаагчдын хамрагдалт	100%	100%	
7	Албан хаагчдын нийгмийн асуудалд зарцуулсан зардал	7.1	Албан хаагчдын нийгмийн асуудалд зарцуулсан зардлын хэмжээ /сая.төг/	51.6 сая төгрөг	52.4 сая төгрөг	Төрийн албаны тухай хууль, Засгийн газрын 2024 оны 83 дугаар тогтоол, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр, Хөдөлмөрийн дотоод журамд заасны дагуу тэтгэмж, урамшууллын зардалд 76.4 сая төгрөгийг зарцуулсан.
Хэсгийн дундаж: 100%						
Үнэлгээний дундаж хувь: 100%						

Биелэлт гаргасан: Ахлах дотоод аудитор

Хянасан: Дарга


А.Буюндэлгэр


Д.Гандолгор